



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/СБ

Бөхт

Засаг даргын нөөцөөс хөрөнгө зарцуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 5 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор орчин үеийн цаг уурын ажиглалтын автомат станц байрлуулахад шаардлагатай хүчдэлийн цахилгаан дамжуулах утас болон бусад материалын зардалд 3,502,300 (гурван сая таван зуун хоёр мянга гурван зуун) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх үйл ажиллагааны зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал)-д, санхүүгийн гүйлгээ хийхийг нягтлан бодогч (Б.Өлзийням)-д зөвшөөрсүгэй.

3. Холбогдох санхүүгийн баримт бүрдүүлж ажиллахыг нярав (Т.Батбилэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ

4823010129